

## **“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Тус компани нь 2016 оны жилийн эцсийн байдлаар 12,6 тэрбум төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй ажиллаж, 11,5 тэрбум төгрөгийн орлого оруулан, 91.9 хувийн биелэлттэй ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 15 хувиар нэмэгдсэн /урьдчилсан байдлаар/ үзүүлэлттэй байна.

2016 онд хийж хэрэгжүүлэхээр зорьсон 8 үндсэн чиглэлээр, 178 ажил төлөвлөснөөс 162 ажлыг биелүүлж, 91%-ийн гүйцэтгэлтэй ажиллаа.

Компанийн хэмжээгээр өнөөдрийн байдлаар 912 хүн ажиллаж байгаагаас Улаанбаатар хотод 397, орон нутагт 515 хүн ажиллаж байна. Нийт ажилтныг нас, хүйсээр нь харьцуулбал, эмэгтэй - 67.8%, эрэгтэй - 32.2%, 29 хүртэлх насны хүн - 18.2%, 30-39 насны хүн-28%, 40-50 насны хүн 34.4%, 51-ээс дээш насны хүн-19.4%-ийг эзэлж байна.

Компани нь тайлант хугацаанд компанийн үндсэн чиг үүрэг, төлөвлөгөөт болон удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын биелэлтийг хангахаас гадна шуудангийн үндсэн үйлчилгээг идэвхжүүлэх, хүргэлтийн үйлчилгээг өргөжүүлэх, логистикийн үйлчилгээг сайжруулах, цахим технологийн бизнесийг нэвтрүүлэн хөгжүүлэх зорилтуудыг дэвшүүлэн, дараах чиглэлээр ажиллаа. Үүнд:

### **НЭГ. ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР**

#### **1.1. Шуудангийн үндсэн үйлчилгээг идэвхжүүлэх зорилтын хүрээнд:**

##### *а/ Шуудангийн солилцооны үзүүлэлт*

Тайлант хугацаанд шуудангийн сүлжээг хөгжүүлэх, сүлжээний байнгын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах хүрээнд дотооддоо хот хооронд авто тээврээр 35871 богц буюу 279501,9 кг шуудан, агаараар 5548 богц буюу 124410 кг, төмөр замаар 7719 богц буюу 21916,8 кг орон нутгийн шуудан, Улаанбаатар хотын дотор 73974 богц буюу 367212,1 кг, улс хооронд газраар 109845 богц буюу 646714 кг, агаараар 43798 богц буюу 335527,4 кг солилцож хүргэсэн.

Нийт 1314687 ширхэг бичиг захидал, боодол, 39309 ширхэг гадаад, дотоод илгээлт, 93027 ширхэг гадаад, дотоод буухиаг ялган боловсрууллаа.

##### *б/ Шуудангийн илгээмжийн үйлчилгээ*

Улс хоорондын бичиг захидлыг дамжуулах транзит орнууд дээр харьцуулсан судалгаа хийн, маршрут чиглэлийг оновчтой болгон өөрчилж, 2016 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөж байна.

Буухиа солилцдог орнуудын тоо 34 байсан бол тайлант хугацаанд Итали, Испани, Филиппин, Финлянд улс нэмэгдсэнээр 38 оронтой буухиа шуудан солилцдог боллоо. Цаашид буухиа шуудангийн холбоонд нэгдсэн бүх оронтой шууданг солилцох зорилт тавин ажиллаж байна.

Улс хоорондын шуудан илгээмжийн идэвхжүүлэлтийн ажлыг зохион байгуулж хэрэгжүүлснээр солилцоо өмнөх оны мөн үеийнхээс 3.5 хувиар /урьдчилсан байдлаар/ өссөн дүнтэй байна.

“Монгол шуудан” ХК нь улс хоорондын буухиа шуудангийн чанарын үзүүлэлтээрээ дэлхийн 201 орноос V байр эзэлж, Дэлхийн шуудан холбооны “Алтан өргөмжлөл” хүртэж, цом өргөмжлөл авлаа.

Гаалийн хяналтанд саатуулагдсан болон агуулахад байгаа илгээмжийн тоо ширхэгийг дэлгэрэнгүйгээр өдөр бүр гаргаж, хаяг нь тодорхойгүй, хяналтын хугацаа хэтэрсэн 128 ширхэг буухиа, 25 ширхэг илгээлтийг явуулагч улс руу нь буцаан, хяналт тавьж ажиллав.

Шуудангийн үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ болох бичиг захидал, ил захидлын үйлчилгээг сурталчилан таниулах зорилгоор ICT EXPO 2016 үзэсгэлэнд идэвхтэй оролцож, 800 орчим мэндчилгээ, ил захидлыг иргэдээр бичүүлэн маркжуулж, хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

ДШХ-оос бичиг захидлын хүргэлтийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд 2016 он дуустал ОХУ-тай төстийн бичиг захидлыг солилцох ажлыг зохион байгуулан, ажиллаж байна. Мөн улс хоорондын и-худалдааны илгээмжийг бүртгэлжүүлэх, нэгдсэн төлбөр тооцоотой болгох бэлтгэл ажлын хүрээнд БНСУ-тай эхний төстийн ажлыг нэг сарын хугацаанд хийлээ.

Илгээмжийн 250 гр хүртэлх жинтэй гадаад энгийн боодлыг хүлээн авахад дүрмийн болон тарифын зөрчил үүсч байсныг залруулах үүднээс жингийн шатлалд өөрчлөлт оруулж, мөрдүүлэн ажиллаж байна.

EZPOST буюу нэг хэрэглэгчээс овор ихтэй болон олон ширхэгтэй илгээмжийн очиж авах үйлчилгээг сурталчлан хэрэгжүүлэх ажлыг шуудангийн үйлчилгээний 21, 28, 34, 37, 38, 44, 46, 48-р салбарууд зохион байгуулж, 133,3 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Шуудангийн үйлчилгээг сурталчилан таниулах ажлын хүрээнд МҮОНРТ-тай хамтран ажиллах гэрээ байгуулан, “Ээждээ бичих захидал” цуврал нэвтрүүлэгт ирсэн 500 орчим захидлыг хаягт эзэнд нь хүргэх ажлыг зохион байгуулсан.

Шинэ жилийн баярыг тохиолдуулан, “Өвлийн өвөөд захидал илгээе” сэдэвт захидлын уралдаан зарлаж, нийт 15 мянга гаруй захидал хүлээн авч, шилдгүүдийг тодруулан, МҮОНРТ-ийн нэвтрүүлэгт оролцуулсан нь компанийн үйл ажиллагааг сурталчилсан үр дүнтэй ажил болсон.

### ө/ Шуудангийн хайрцаг, ухаалаг шуудангийн хайрцагны үйлчилгээ

Шуудангийн хайрцагны эзэмшлийг сайжруулах, хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор шуудангийн хайрцагны алт, мөнгө, хүрэл дугаар эзэмшүүлэх төсөл боловсруулсан ба “Барилга орон сууцны тухай”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд “Орон сууцны барилга өрхийн тоогоор шуудангийн хайрцагтай байх ба цогцолбор хорооллын хувьд шуудангийн үйлчилгээний цэг байгуулна” гэсэн заалт оруулах тухай санал хүргүүлсэн.

Сүхбаатар дүүргийн томоохон зах, үйлчилгээний төв, дэлгүүрүүдэд 36-72 нүдтэй шуудангийн хайрцаг байрлуулж, хэвлэл захиалга авах ажлыг 12-20 дугаар хороодтой хамтран хийж, “Бүрэн плаза” үйлчилгээний төвд болон зусланд байрлах Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хороонд хайрцаг байрлуулж, хэрэглэгчдээс захиалга авч эхлээд байна.

Нийслэлийн Үйлчилгээний Нэгдсэн Төвүүдэд шуудангийн үйлчилгээний цэг байгуулах, шуудангийн үйлчилгээг сурталчилан таниулах, иргэн аж ахуйн нэгжүүдэд

төрийн үйлчилгээг ойртуулах чиглэлээр нийслэлийн үйлчилгээний Дүнжингарав салбарт шуудангийн цонх байгуулан, Драгон, Мишээл салбаруудад ухаалаг шуудангийн хайрцаг байршуулж, 230 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг аж ахуйн нэгж, иргэдэд үзүүлж байна.

Ухаалаг шуудангийн хайрцагаар 788 илгээмж гардуулсан ба 311 хэрэглэгчидтэй хайрцаг хэлбэрээр утасны дугаартай адил дугаараар эзэмшүүлэхээр гэрээ хийлээ.

#### г/ Марк, үнэт цаасны үйлдвэрлэл

Марк, үнэт цаасны борлуулалтаар 110 сая төгрөгийн төлөвлөгөөтэй ажиллаж, 118,3 сая төгрөгийн орлого оруулан, 107,5%-ийн биелэлттэй ажилласан. Түүнчлэн 368 сая төгрөгийн зардлын төлөвлөгөөтэй ажилласнаас 302 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, төлөвлөгөөт зардлаа 66 сая төгрөгөөр хэмнэж ажилласан.

Зөвхөн [www.mongolstamps.com](http://www.mongolstamps.com) маркийн онлайн худалдааны сайтаар дамжуулан, 700 гаруй нэр төрлийн монгол маркийг борлуулж, 14 690 ам доллар, 6.6 сая төгрөгийн орлого ороод байна.

Энэ онд "Хотол дөрвөн бэлгэдэл", "Монгол гэр, үндэсний хувцас", АСЕМ-11", "Өмч хувьчлалын 25 жилийн ой", "Мэргэн сайд Амар", "Ардын хувьсгалын 95 жил" "Зуны XXXI олимп" зэрэг 14 сэдвийн маркийг гүйлгээнд гарган, нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, анхны өдрийн дугтуйг гар аргаар хийж, худалдан борлуулсан.

Улаанбаатар хотын салбарууд аялал жуулчлалын улирлыг ашиглан, жуулчны бааз, музей, зочид буудлуудтай гэрээ байгуулан, гадуур орлого хийж, 15,7 сая төгрөгийн марк, үнэт цаас борлуулсан байна.

Шинээр гаргасан ил захидал мэндчилгээг гэрээтээр авч борлуулах ажлыг зохион байгуулж, 13,7 сая төгрөгийн, өөрсдийн дотоод нөөц бололцоогоо ашиглаж, 16 нэр төрлийн мөнгөний дугтуйны загвар гарган хэвлүүлж, 14 орчим сая төгрөгийн борлуулалт хийсэн.

Дугтуйны үйлдвэр нь 6 нэр төрлийн 1,334 мянган ширхэг дугтуй, 642.5 мянган ширхэг анхан шатны маягт, бүртгэлийн дэвтэр, 447.3 мянган ширхэг RD, RC, EE код, маягтыг үйлдвэрлэж, аймаг, салбар, нэгжүүдээр худалдаалах болон шуудангийн дотоодын хэрэгцээнд нийлүүлсэн.

Авто Тээврийн Үндэсний Төвтэй сумдад зорчигчийн тийз бичих үйлчилгээг сумын шууданчдаар хийлгэх, аймаг сумдын хооронд шуудан тээврийн давтамжийг нэмэгдүүлэх, хот хоорондын шуудан тээвэр, хот хоорондын ачаа тээврийн хяналтыг хамтран хэрэгжүүлэх, Улаанбаатар-Эрээн чиглэлийн автобусаар зорчигчдын ачааг логистик үйлчилгээгээр явуулах талаар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.

#### д/ Үйлчилгээний чанар

Хэрэглэгчдээс 94 ширхэг өргөдөл гомдлыг хүлээн авч, хохирол барагдуулах актаар 12 хэрэглэгчдийн хохирлыг барагдуулж, 82 өргөдөл гомдлыг цаг тухай бүрт нь хугацаа алдалгүй шийдвэрлэсэн бөгөөд одоогийн байдлаар 6 хэрэглэгчдийн өргөдөл гомдол шийдвэрлэх шатандаа явж байна.

Хэвлэл ялган боловсруулах хэсэгт гэрээт цагаасаа хоцорч ирсэн хэвлэлийн бүртгэл тооцоог нарийвчлан гаргаж, 1.6 сая төгрөгийн торгуулийн төлбөрийг төвлөрүүлсэн.

Шуудангийн илгээмжийн хүргэлтийн чанарыг сайжруулахын тулд Бямба, Ням гарагийн хүргэлтийн ажлыг 20, 23, 28, 32, 34, 35, 36, 37, 40, 49, 51 зэрэг салбаруудад зохион байгуулж, нийтдээ 10087 ширхэг илгээмжийг хаягт эзэнд нь гардуулав.

Хэрэглэгчийн Үйлчилгээний Хэсгийн 1800-1613 лавлах утсаар илгээмжийн лавлагаа, шуудангийн үйлчилгээний талаарх мэдээллийг авахаар хандсан 53460 хэрэглэгчид мэдээллийг хурдан шуурхай өгч ажиллаа.

## **1.2 Хүргэлтийн бизнесийг өргөжүүлэх зорилтын хүрээнд:**

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын салбар нэгжүүд, хэрэглэгчийн албаны болон гэрийн хаягаар 3947 хэрэглэгчдэд, салбарын шуудангийн хайрцгаар 10 859 хэрэглэгчдэд, аймаг сумдад албаны болон гэрийн хаягаар 6755 хэрэглэгчдэд, салбарын шуудангийн хайрцгаар 4717 хэрэглэгчдэд хүргэлт хийж байна.

### *а/ Хүргэлтийн үйлчилгээг сайжруулж, нэр төрлийг нэмэгдүүлэх*

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаас санхүүжүүлж байгаа “Шуудангийн салбарын үйлчилгээний хүргэлтийн давтамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх” ХААГ-2016/ЭШ-05 тоот төслийн ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төслийн тодорхойлолтод заагдсан 12 аймгийн сум, багийн шуудан хүргэлтийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж, давтамж нэмэгдүүлэх чиглэл болон тээвэрлэлтийн хэлбэрийг сонгон, маршрут, графикийг батлуулаад байна.

2016 оны 11 дүгээр сараас Цагдаагийн Ерөнхий Газрын Лицензийн төвтэй хамтран, жолооны үнэмлэх шинээр авах, солиулах, нөхөн авах иргэд үнэмлэхээ хүргүүлэхдээ ТҮЦ машин, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв, [www.ezasag.mn](http://www.ezasag.mn) сайтаар дамжуулан, нийслэл, хөдөө орон нутагт ажил болон гэртээ хүргүүлэн авах боломж бүрдсэн нь иргэдийн цаг завьг хэмнэсэн, түргэн шуурхай, гараас гарт хүргэсэн, төрийн түгжрэлгүй үйлчилгээг дэмжсэн томоохон ажил боллоо.

Сүүлийн жилүүдэд компанийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэг нь торгуулийн хуудасны хүргэлт юм. Тайлант хугацаанд 385636 ширхэг торгуулийн хуудас ялган боловсруулж хүргүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 60188 ширхэгээр буурсан хандлага ажиглагдаж байна. Энэ нь Замын Хөдөлгөөний Удирдлагын Төвийн шуудан хүргэлтийн төсөв бага батлагдаж, торгуулийн хуудас хүргэх ажил зогсох асуудал үүссэнтэй холбоотой юм..

УБЕГ-тай байгуулсан гэрээний дагуу гадаад паспортыг хаягаар хүргэх ажлыг идэвхжүүлэн хөгжүүлэх чиглэлээр хийгдсэн ажлуудын үр дүнд 7067 ширхэг гадаад паспорт, 250 ширхэг улсын бүртгэлийн гэрчилгээ хүргэж, 32 сая төгрөгийн орлого олох урьдчилсан төлөвтэй байна.

Шүүхийн Ерөнхий Зөвлөлтэй хамтран, бүх шатны шүүхийн байгууллагуудын шүүхийн зарлан дуудах, мэдэгдэх хуудсыг гибрид шуудангаар хүргүүлж, 2016 онд 44741 ширхэг хүргэгдэж, 63 сая төгрөгийн орлого төвлөрүүллээ.

2016 оны 06 дугаар сараас “Мобиком корпораци”-ийн шинэ хэрэглэгчдэд 2472 ширхэг талархлын захидлыг гибрид шуудангаар хүргэлээ.

Тайлант оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, шуудангийн үйлчилгээний 20а, 38, 44, 46, 46а, 48-р салбаруудаар үйлчлүүлдэг төрийн байгууллагуудын хооронд “А” бүсийн хүргэлтийг зохион байгуулж, өдөртөө 254 ширхэг албан бичиг гардуулж байна.

Эртийн хүргэлтээр Улаанбаатар хотод өглөөний 04.00-07.30 цагийн хооронд давхардсан тоогоор 324 албан байгууллагад 176158 ширхэг хэвлэлийг хүргэлээ.

2016 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн, Улаанбаатар хотоос Дархан-Уул аймагт 7 хоногт 5 удаа шуудан хүргэлт хийгддэг байсныг 6 болгон 1-ээр нэмэгдүүлэв.

Карт эзэмшигчийн гэрээг хүргэх ажлыг 2017 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөж, “Хаан банк”-тай гэрээ байгуулаад байна.

“Мобиком” ХХК-тай 5 чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, одоогийн байдлаар 3 чиглэлийн хамтын ажиллагааг эхлүүлээд байна.

#### *б/ Төрийн үйлчилгээний нэгдсэн төвүүдэд шуудангийн салбар байгуулах, гарч байгаа бүтээгдэхүүнийг хаягаар хүргэх*

Дүнжингарав, Мишээл, Драгон худалдааны төвд байрлах “Нэг цэгийн үйлчилгээний нэгдсэн төв”-өөс гарах бүтээгдэхүүн үйлчилгээг хаягаар хүргэн өгч үйлчилдэг боллоо. Ялангуяа Дүнжингарав худалдааны төвд 2016 оны 06-р сарын 01-ний өдрөөс шуудангийн үйлчилгээг үзүүлж, 2.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. Дүнжингарав салбарт лицензийн төв, ОӨУБЕГ 2016 оны 11-р сараас иргэд, аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлж эхэлснээр өдөрт дунджаар 20-30 ширхэг жолооны үнэмлэх, 5-10 ширхэг гадаад паспорт хүргэх захиалга авч байгаа ба энэ тоо цаашид өсөх хандлагатай байна.

#### *в/ Гибрид шуудангийн үйлчилгээ, торгуулийн хуудасны хүргэлтийг орон нутагт нэвтрүүлэх*

Гибрид шуудангийн үйлчилгээг Дархан-Уул, Орхон, Өвөрхангай аймгуудад нэвтрүүлсэн. Цаашид сумдын ШҮС сүлжээнд холбогдож, компьютерээр хангагдвал энэхүү үйлчилгээ нэвтрэх бүрэн боломжтой юм.

Энэ оны эхнээс торгуулийн хуудсыг орон нутагт хүргэх ажлыг Булган, Хөвсгөл аймгийн ШҮГ-аас эхэлж хэрэгжүүлсэн боловч аймгийн Замын Цагдаагийн Хэлтэст зөрчлийг илрүүлэх орон тоо батлагдаагүй, байр талбайн хүртээмж муу байгаа учир бусад аймгуудад нэвтрэх боломжгүй байдалд ороод байна.

### **1.3 Цахим технологийн бизнесийг нэвтрүүлэх, хөгжүүлэх зорилтын хүрээнд**

#### *а/ Онлайн хэвлэл захиалгын бизнесийг нэвтрүүлэх*

Онлайн хэвлэл захиалгын програм хангамжийг боловсруулан, хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж байгаа ба 2017 оны хэвлэл захиалгын гэрээнд дээрх үйлчилгээтэй холбоотой заалтуудыг тусгах, цаашдын хөгжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

#### *б/ Дотоод, гадаадын онлайн худалдааны сайтуудаар хүргэлтийн ажлыг эхлүүлэх*

“Монгол шуудан” ХК нь дотоодын онлайн худалдааны сайтуудын бараа бүтээгдэхүүнийг хүргэх ажлыг туршилтын хугацаанд эхлүүлээд байгаа бөгөөд Улаанбаатар хотын доторх хүргэлтийн тариф өндөр, мөн явганаар хүргэлт хийдэг, хүргэлтийн хугацаа урт зэрэг шалтгаануудаас хотын доторх хүргэлтийг сайтууд

өөрсдөө болон жижиг хүргэлтийн байгууллагуудаар хийлгэж байна. Онлайн худалдааны сайтуудын хувьд ихэвчлэн хөдөө орон нутгийн хүргэлтийг “Монгол шуудан” ХК-аар гүйцэтгүүлэх сонирхолтой байгаа ба дотоодын логистик үйлчилгээг нэвтрүүлж, үнэ тарифыг тодорхой болгосноор өсөн нэмэгдэх боломжтой юм.

Өөрийн сүлжээний давуу талыг ашиглан хүргэлтийн ажлыг хийх саналыг онлайн худалдааны сайтуудад хүргүүлэн, эхнээс нь [www.rto.mn](http://www.rto.mn)-тэй хамтран ажиллаж, 2016 оны 9 дүгээр сарын байдлаар 616,4 мянган төгрөгийн орлого олов.

Худалдааны цахим хуудастай хамтран ажиллах гэрээний дагуу POSTNETv3 систем нэмэлт сэрвисийг, масс мессежийн програм хангамжийг үйл ажиллагаанд нэвтрүүллээ.

#### в/ Бусад

Улаанбаатар хотын 86 шуудан хүргэгчийг Самсунг J1 гар утсаар хангаж, шуудангийн хүргэлтийн мэдээллийг цаг тухайд нь POSTNET шуудангийн системд оруулж байна. Шуудан хүргэлтэнд зориулсан ухаалаг үзэгтэй гар утсанд шуудангийн гардуулалтын аппликейшн, хүргэгч нарын явсан маршрут, километрийг хянах GPS систем, Монгол Улсын зип кодын мэдээллийн сангийн аппликейшнуудыг багтаасан ба ингэснээр хүргэгч нар хүргэлтийн дэвтрийг авч явах шаардлагагүй, хүргэлтийн өмнө болон дараа ажил дээрээ гараар шуудангийн мэдээллийг постнет системд оруулах, дэвтэрт бичих, кассууд хяналт тавин, нөхөж оруулах зэргийг хөнгөвчилсөн ажил байлаа.

Улаанбаатар хотын бүх салбаруудын дотоод сүлжээ, суурин утасны шинэчлэл, өргөтгөлийг хийж гүйцэтгэв.

Төв шуудангийн А болон Б зааланд хэрэглэгчдэд зориулсан утасгүй интернетийн сүлжээг зохион байгуулав.

POSTNETv3 системд шинээр нэмэгдэж буй гар утасны гардуулалтын програм, торгуулийн хуудас, онлайн худалдаа, НӨАТ-ын баримт хэвлэх, хэрэглэгчид мессэжээр төлөв дамжуулах модулиудыг шинээр үйл ажиллагаанд нэвтрүүлэн, хяналт тавин ажиллаж байна.

Шуудангийн үндсэн нэр төрлийн болон шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг сайт, социал групп хуудсанд байршуулснаар хандалт 2 дахин нэмэгдсэн.

### **1.4 Логистик үйлчилгээг сайжруулах зорилтын хүрээнд:**

#### а/ Дотоод логистик үйлчилгээ

2013 оны 11 дүгээр сард шинэчлэлийн засгийн газрын дэмжлэгтэйгээр 880 сая төгрөгийн битүү чингэлэг бүхий ачаа тээврийн 8 автомашинтай болсноор өсөн нэмэгдэж буй зах зээлийн чиг хандлагыг дагаж, логистик ачаа тээврийн үйлчилгээг нэвтрүүлэн, Замын-Үүд-Улаанбаатар хотын чиглэлд тээвэрлэлт хийж эхэлсэн.

Энэхүү үйлчилгээгээр БНХАУ, Монгол Улсын хооронд худалдаа наймаа хийж буй иргэд, ААН-үүд Замын-Үүдээр оруулж ирсэн ачааг тодорхой маршрут, цагийн дагуу тээвэрлэлт хийж байна. 2016 оны эхний 10 сарын байдлаар 230 сая төгрөгийн орлого оруулж, 248,2 сая төгрөгийн зардал гаргажээ. Энэ байдлаас харахад, мөнгөн орлого зардлын үзүүлэлтүүдээр ашигтай байгаа хэдий ч мөнгөн бус зардал болох автомашины элэгдлийн зардал, мөн ашиглалттай холбоотой зардлуудыг тусгаж үзвэл алдагдалтай үзүүлэлт харагдаж байна. Иймд логистик үйлчилгээг зардал бага,

бүтээмж өндөр, хурдан шуурхай байдлаар зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Логистик үйлчилгээг өргөжүүлэх, цаашид тогтмол цаг, маршрутын дагуу тээвэрлэлт хийх талаарх ажлыг санаачлан зохион байгуулж, Авто Тээврийн Үндэсний Төвд санал хүргүүлэн, цаашдын боломжуудыг тодорхойлох, Зам Тээврийн Яам, Авто тээврийн Үндэсний Төв зэрэг байгууллагуудтай хамтран, урт хугацааны бодлого боловсруулах ажлыг эхлүүлээ.

#### б/ ОХУ болон БНХАУ-ын шуудангийн байгууллагуудтай хамтран, хил дамнасан и-худалдааны хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэх

“Монгол шуудан” ХК өнөөгийн байдлаар хил дамнасан и-худалдааны хүргэлтийн үйлчилгээг 2016 оны 02 дугаар сард эхлүүлсэн бөгөөд 2016 оны байдлаар 9110044 ширхэг энгийн болон бүртгэлтэй боодол, 9416 ширхэг илгээлт, 441 ширхэг буухиа шуудан явж, 900-аад сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

2017 онд хил дамнасан и-худалдааны хүргэлтийн үйлчилгээг “Монгол Шуудан” ХК дан ганц ОХУ-руу хийгээд зогсохгүй Европын 6 улс руу хийхээр захиалагч компанитай яриа хэлэлцээр хийн, туршилтын журмаар ажиллаж байна. Хэрэв энэхүү туршилт амжилттай болсон тохиолдолд 2017 оны 01 дүгээр сараас ОХУ болон Европын улс руу и-худалдааны илгээмжийн хүргэлтийг хийх нөхцөл бүрдэнэ. Илгээгч талын урьдчилсан тооцоогоор Европ руу илгээгдэх шуудангийн хэмжээ ОХУ-руу илгээгдэж буй шуудангаас даруй 3 дахин их хэмжээтэй байхаар тооцоологдож байна.

Хил дамнасан и-худалдааны хүргэлтийн үйлчилгээ явуулж эхэлсэнтэй холбогдуулан, мэдээллийн сүлжээний багтаамжийг 20 мегабайт хурдны сүлжээгээр нэмэгдүүлж, шуудангийн гаалийн үйл ажиллагаанд зориулан, Монголын Цахилгаан Холбоо ХК-аас 1 мегабайт хурдны сүлжээний холболтыг хийлээ.

### **ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ТАЛААР**

#### а/ Хүний нөөц

Тус компанид өнөөдрийн байдлаар 912 хүн ажиллаж байгаагаас Улаанбаатар хотод 397, орон нутагт 515 хүн ажиллаж байна. Нийт ажилтны тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь Улаанбаатар хотод хүргэлтийн үйлчилгээний нэр төрөл өссөнтэй холбоотой боловч хүний нөөцийг чадавхжуулах, хөрвөх чадвартай хүний нөөц бэлтгэх шаардлага тулгараад байна.

2016 онд нийт ажилтны 8% нь ажлаас чөлөөлөгдсөн ба үүний шалтгааны хувийн жинг нийт ажилтны тоотой харьцуулахад, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн-6%, захиргааны санаачилгаар чөлөөлөгдсөн-2%-ийн үзүүлэлттэй байна. Энэ хугацаанд ажилд орсон хүн нийт ажилтны 9%-ийг эзэлж байна. 2016 онд нийт ажилтны бараг 12 хүн тутмын 1 нь ажлаас чөлөөлөгдөж, мөн тооны хүн ажилд орсон байна.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын 95 жилийн ой болон шинэ жилийн баярыг тохиолдуулан төрийн одон медалиар 9, Монголын Залуучуудын Холбооны шагналаар 8, мэдээлэл харилцаа холбооны салбарын шагналаар 35, компанийн шагналаар 73 ажилтныг тус тус шагнаж урамшуулжээ.

Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүдийн хөдөлмөрийн хэлтэстэй хамтран ажиллах “Ажил олгогчид урамшуулал олгох арга хэмжээний гэрээ” байгуулахаар хүсэлт гарган, одоогийн байдлаар Хан-Уул

дүүргийн хөдөлмөрийн хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулж, ажил олгогчийг дэмжих урамшуулал авахад бэлэн болоод байна.

#### б/ Хууль эрх зүй

2016 оны “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажилласан.

Компанитай холбоотой хууль эрх зүйн чиглэлийн бүх асуудлыг цаг тухай бүрт нь шийдвэрлэн, компанийн үйл ажиллагаа, авилга, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлтийг хүлээн авах цэсийг шинэчилж, цахим хуудсанд байршуулснаар асуудлыг зохих шатны мэргэжилтнээс тодруулах шийдвэрлэх боломжтой болгосон.

Хувьцаат компани болон өөрчлөгдсөнтэй холбогдуулан, “Компанийн дүрэм”-д 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, 2016 оны 09 дүгээр сарын 09–ний өдөр шинэчлэн найруулж, мөн өдрөөс мөрдлөг болгон ажилласан. Мөн “Хөдөлмөрийн гэрээ”-г нийт ажилтнуудтай шинэчлэн байгуулж, компанийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, тамга тэмдэг, хэвлэмэл хуудас зэргийг шинэчлэлээ.

Албан хэрэгцээний суурин болон зөөврийн компьютер худалдан авах, автогаражийн өргөтгөлийн ажил гүйцэтгүүлэхээр тендерийн материалыг боловсруулж, зохион байгуулж гүйцэтгэсэн.

#### в/ Нийгмийн асуудал

Ажилтны эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх орчин нөхцлөөр хангах зорилгоор бялдаржуулах танхимыг стандартын дагуу ажиллуулж, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажлын байрны нөхцлөөс хамааруулан, зарим ажилтанд нормын сүү, сүүн бүтээгдэхүүнийг тогтмол олгуулж байна.

Цагаан сарын баяр, шууданчдын баярыг тохиолдуулан, ахмад настнууд, ажиллаж байгаа болон өндөр насны тэтгэвэрт гарсан “Хүндэт шууданч” нарт 9,3 сая төгрөгийн нэмэгдэл тэтгэмжийг олгосноос гадна тэднийг хүлээн авахад зориулж, 10,9 сая төгрөг зарцуулсан байна.

Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”, компанийн “Хөдөлмөрийн дотоод журам”, захиргаа ҮЭХ-ны хооронд байгуулсан “Хамтын гэрээ”-г өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж, ажилтны ар гэрт нь хагацал тохиолдсон 15 ажилтанд 3,800 мянган төгрөгийн, нас барсан 7 ахмад настанд 700 мянган төгрөгийн, ойр дотных нь хүн нас барсан 7 ажилтанд 700 мянган төгрөгийн тэтгэмж, хүндээр өвдсөн 3 ажилтанд 600 мянган төгрөгийн, гэнэт гамшиг осол тохиолдсон 2 ажилтанд 2 сая төгрөгийн, хүндээр өвдсөн 8 ахмад настанд 800 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, компанийн хоорондоо гэр бүл болсон 1 хосод 500 мянган төгрөгийн тэтгэмжийг үзүүллээ.

Шинэ жилийн баярыг тохиолдуулан, тус компанид ажиллаж байгаад насан өөд болсон ажилтнуудын 18 хүртэлх насны хүүхдүүдэд сурлагын өндөр амжилт хүсч, ирээдүйдээ улс, эх орондоо хэрэгтэй хүн болохын ерөөлийг дэвшүүлж, гарын бэлэг гардууллаа.

Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ШШГЕГ-тай хамтарч, Эх үрсийн баярыг тохиолдуулан Улаанбаатар хотын болон хөдөө орон нутгийн хорих ангиудад хоригдож байгаа ял эдлэгсдийг ар гэрийн хүмүүстээ үнэ



төлбөргүй 5000 ширхэг захидал бичүүлэн, хаягт эзэнд нь хүргэх ажлыг амжилттай зохион байгууллаа.

“Хот Хоорондын Тээвэр Эрхлэгчдийн Холбоо” болон Үйлвэрчний Эвлэлийн Хороотой хамтран, компанийн 36-р салбарын хүргэгч Д.Мөнхцэцэгт 5 ханатай, иж бүрэн тавилгатай гэр бэлэглэж, түүний нийгмийн асуудлыг шийдвэрлэв.

### г/ Дотоод ажил

Аймгийн ШҮГ-ын ажилтнуудтай 2016 оны орлого, зардал, солилцооны төлөвлөгөө, цаг үеийн асуудал болон хүний нөөц, цаг бүртгэлийн програмд сайжруулалт хийсэнтэй холбогдуулан, онлайн хурлыг зохион байгуулж, ерөнхий чиглэл өгч ажиллав.

“Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт өөрчлөлт оруулан, “Цагийн бүртгэл, ажлын цаг ашиглалтад хяналт тавих журам”-ыг шинэчлэн, 2016 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Компанийн хэмжээнд 2421 ширхэг албан бичиг ирсэн ба үүний 2280 ширхэг нь хариугүй, 141 ширхэг нь хариутай албан бичиг ирсэн, хариутай бичгийн 93% нь шийдвэрлэгдсэн, 7% нь шийдвэрлэгдэх шатандаа явж байна.

Ажилтнуудаас 203 ширхэг өргөдөл хүлээн авсны 95%-ийг шийдвэрлэж, 5% нь шийдвэрлэх хугацаандаа байна.

Компанийн аймгийн ШҮГ-ын дарга нарын сарын үндсэн цалинг 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс тус бүр 100 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

Гүйцэтгэх захирлын 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/46 тоот тушаалаар батлагдсан “Шуудангийн анхан шатны баримтыг хөтлөх, бүртгэн архивлах, хадгалах, устгах журам”-ын дагуу хадгалах хугацаа нь дууссан 3161ш архивын материалыг устгах ажлыг зохион байгууллаа.

Гүйцэтгэх захирлын 2016 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/04 тоот тушаалаар “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах журам”, “Компанийн ажилтнуудын мөрдөх аюулгүй ажиллагааны журам”, “ХАБЭА-н аюулгүй ажиллагааны зааварчилгааны журам”-уудыг батлуулан, мөрдлөг болгон ажиллаж байна.

### д/ Сургалт

Албан тушаал ахих хүсэлтэй, тавигдах шаардлагыг хангасан хүргэгч нарт ахисан түвшний сургалт зохион байгуулж, 21 хүргэгчийг хамруулан, хангалттай үнэлгээ үзүүлсэн 10 хүргэгчийг шалгаруулан, эхнээс нь кассын албан тушаалд томилон ажиллуулж байна.

Шуудангийн үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран, амьдрах ухаан болон гоо зүйн сургалтуудыг зохион байгуулж, шинээр ажилд орсон ажилтнуудад мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор 38 хүнийг шинэ ажилтны сургалтанд хамруулсан.

## **ГУРАВ. БУСАД АЖЛЫН ТАЛААР**

### а/ Санхүү

НӨАТ-ын буцаан олголт, ebarimt.mn-ийн өөрчлөлт, НӨАТ-ын баримт хэвлэх, POS-ын системийг нэвтрүүлж байна. Гарсан алдаануудыг НӨАТ-ын урамшууллын

системийн ажилтанд хандан, алдааг засуулж, сар бүр тайланг цаг тухайд нь гарган өгч ажилласан.

Найдваргүй авлагыг ТУЗ-ийн хурлаар оруулан батлуулж, 318,6 сая төгрөгийн авлагыг дансанд бичилт хийж хаасан.

Төрийн болон орон нутгийн өмчийг 4 жилд нэг удаа тоолдог нэгдсэн тооллогын материал, Статистикийн Ерөнхий Газраас 5 жилд нэг удаа гаргадаг статистик судалгаа, Үндэсний Татварын Ерөнхий газраас ирүүлсэн судалгаа, Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос хийсэн шалтгалтуудад холбогдох баримт материалуудыг тус тус гаргаж өгсөн.

“Монгол Шуудан” ХК-ийн худалдан авалтын төлөвлөгөөг олон нийтэд зарлан, шилэн дансны хуулийг мөрдөж ажиллах чиг үүргийг хэрэгжүүлж, Засгийн Газар, Сангийн Яамны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [pmmis.mof.gov.mn](http://pmmis.mof.gov.mn) сайтуудад төлөвлөгөөг байршуулах, худалдан авалтыг зарлах, хөтлөх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Компанийн дугтуйны үйлдвэрт үйлдвэрлэгддэг болон зайлшгүй шаардлагын үүднээс гэрээгээр татан борлуулдаг нийт 17 төрлийн дугтуйны нэг бүрийн өртөг, худалдах үнийг зах зээлийн нөхцөл шаардлагад нийцүүлж, шинэчлэн тогтоон, тушаалаар баталгаажуулан мөрдүүлсэн. “Хүннү эйр” компанитай хамтран ажиллах гэрээний хүрээнд экспресс үйлчилгээний тариф, зохион байгуулалтын тушаалыг гаргасан.

#### б/ Гадаад харилцаа

Ази Номхон Далайн болон Дэлхийн Шуудангийн Байгууллагын ээлжит хуралдаануудад ажилтнуудыг хамруулан, Дэлхийн Шуудан Холбооны олон улсын Байгууллагаас зохион байгуулж буй Ази-Номхон далайн бүсийн улсуудад зориулсан 2016 оны тэтгэлэгт сургалтанд 3 ажилтанг хамрууллаа

ОХУ-ын Буриадын шуудангийн байгууллагатай орос хэвлэлийн захиалгын гэрээг байгуулсан.

#### в/ Аж ахуй, хангамж

Аймгуудын ШҮГ-аас шаардагдсан болон техникийн комиссын актын дагуу технологийн авто машинуудын сэлбэгийг хурдан шуурхай нийлүүлэн, хотын бүх машинуудыг авто оношлогоонд хамруулж, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулсан.

Хүнд даацын автомашины автогаражийн өргөтгөлийг “Онъ тэнгэрийн бичиг” ХХК-аар, шуудангийн төв байрны гадна фасадны засварыг Мэдээлэл холбооны “Сүлжээ” ТӨК-тай хамтарч, Баядах-Өргөө ХХК-аар, шуудангийн төв байрны А, Б заалны засварын ажлыг “Өрнөх-Хурд” ХХК-аар хугацаанд нь багтаан гүйцэтгүүлж ажиллаа.

Маркийн газар, автогаражид галын иж бүрэн самбар, галын хор, тоног төхөөрөмжийн хамт байршуулсан.

### **ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ ТАЛААР**

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоолын дагуу “Монгол шуудан” ТӨХК-ийн нийт хувьцааны 34 хувь буюу 33,859,363 ширхэг хувьцааг 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Монголын

хөрөнгийн биржээр дамжуулан арилжиж, 6,263,982,155 төгрөгийг 256 хувьцаа эзэмшигчдээс татан төвлөрүүлсэн байна.

Хувьцааны хоёрдогч зах зээл дээрх арилжаа 2016 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр 212.12 төгрөгийн ханшаар эхэлж, 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 326.00 төгрөгт хүрч, хамгийн дээд үнийг тогтоож байсан. 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар тус компанийн хувьцаа 339.86 төгрөгийн ханштай байна. Хувьцааны ханш анхны нэрлэсэн ханшаас 88.8%-аар өсөөд байна. Хөрөнгийн бирж дээрх компанийн үнэлгээ өнөөдрийн байдлаар 33.8 тэрбум төгрөг байна. Өнгөрсөн хугацаан дахь компанийн хувьцааны ханшийн хэлбэлзлийг (хаалтын ханш) харвал:



“Монгол шуудан” ХК анх хувьцаа гаргахад хувьцааны захиалга нийлүүлэлтээс 2 дахин их байсан бөгөөд богино хугацаанд ханш огцом өссөн. Өнгөрсөн хугацаан дахь хувьцааны ханш анх нэрлэсэн ханшнаас буугаагүй тогтмол өндөр байж ирсэн нь компанид итгэх итгэл өндөр байгааг харуулж байна. Өнгөрсөн хугацаанд “Монгол шуудан” ХК-д хөрөнгө оруулсан хувьцаа эзэмшигчид хөрөнгө оруулалтаа 60 гаруй хувиар өсгөөд байна.

Санхүүгийн харьцаанууд		2016.III
Нийт хөрөнгийн өгөөж	ROA	0,0183
Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж	ROE	0,0020
Нэгж хувьцааны өгөөж	EPS	4,1117
Үнэ ашгийн харьцаа	P/E ratio	72,9625
Нэгж хувьцааны үнэ		300
Нийт хувьцааны тоо		99,586,363

2016 оны III улирлын байдлаар нэгж хувьцааны өгөөж /EPS/ нь 4.1, үнэ ашгийн харьцаа /P/E ratio/ нь 72.9 байна. Ирэх онд хөрөнгө оруулалтыг үр ашигтай хийснээр компанийн үндсэн үйл ажиллагаа эрчимжиж, логистик, транзит тээврээс олох орлого нэмэгдэж, санхүүгийн үйлчилгээ нэвтрүүлж эхэлснээр хувьцааны эрэлт өсөх, ханш өсөх боломжтой болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 16/23 тоот тогтоолыг үндэслэн, компанийн бүтцэд өөрчлөлт оруулан, шинэ бүтцээр үйл ажиллагаагаа явуулж байна.

#### 5 ХУВИАС ДЭЭШ ХУВЬ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Овог Нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцаа
1	Төрийн өмч	Тодорхой бус	66.00 %
2	Ард Санхүүгийн Нэгтгэл ХК	Тодорхой бус	16.71 %
3	Хишигдорж Батхишиг	"Хишиг Арвин Индустриал" ХХК-ийн Гүйцэтгэх захирал	13.05 %

#### ТАВ. ДҮГНЭЛТ, ЗОРИЛТ

Тайлант онд дэвшүүлсэн 4 зорилтыг хэрэгжүүлэх, төлөвлөгөөт 178 ажлыг биелүүлэх чиглэлээр анхааран ажиллаа.

Шуудангийн үндсэн нэр төрлийн болон уламжлалт шуудангийн үйлчилгээг идэвхжүүлж, жилийн дундаж өсөлтийг ханган ажиллах зорилтын хүрээнд бизнес төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулсан хэдий ч Монгол орны эдийн засгийн байдал хүндэрсэн, иргэдийн худалдан авах чадвар муудсан, цахим технологиуд хөгжиж байгаа, улс хоорондын карго үйлчилгээ эрхлэгчид олширсон зэрэг шалтгаануудаас зарим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний орлого буурах хандлагатай байна. Цаашид үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг цаг үеийн нөхцөл байдалд тулгуурлан, шинэ шатанд хөгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Хүргэлтийн бизнесийг өргөжүүлэх зорилтын хүрээнд жолооны үнэмлэхний хүргэлт, Нийслэлийн Үйлчилгээний Нэгдсэн Төвийн албан бичгийн хүргэлт, гибрид шуудангийн хүргэлт, торгуулийн хуудасны хүргэлтийг өргөжүүлэх чиглэлээр тодорхой ажлууд зохион байгуулж ажилласнаар тайлант хугацаанд хүргэлтийн үйлчилгээнээс нийт 950,0 орчим сая төгрөгийн орлого олсон байна. Энэ нь Шуурхай Удирдлагын Төвийн шуудан хүргэлтийн зардлын төсөв дууссантай холбоотойгоор өмнөх оны мөн үеэс 10 орчим сая төгрөгөөр буурах урьдчилсан дүн мэдээтэй байна. Цаашид төсвийн байгууллагуудын шуудан хүргэлтийн төсөв болон төсвийн тодотголоор хэдэн төгрөг тусгуулах боломж байгаа талаар нарийн судалж, нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Цахим технологийн бизнесийг өргөжүүлэх зорилтын хүрээнд онлайн хэвлэл захиалгын програм хангамж хийх, хэвийн үйл ажиллагааг хангах ажлуудыг эхлүүлсэн. Энэ үйлчилгээ нь шуудангийн ажилтнуудын ажлын ачааллыг бууруулах, өндөр хөгжиж буй цахим технологийг шуудангийн үйлчилгээнд нэвтрүүлэх зэрэг давуу талуудтай үйлчилгээ юм. Мөн энэ зорилтын хүрээнд цахим худалдааны сайтууд болон цахим бизнесийн хүргэлтийн ажлыг эхлүүлэх зорилгоор www.gio.mn сайттай гэрээ байгуулан, туршилтын ажлыг гүйцэтгэсэн. Цахим худалдааны өнөөгийн хөгжил, төлбөр тооцооны асуудал болон техникийн нөхцөл нь бүрэн шийдэгдээгүй тул энэ төрлийн хүргэлтийн ажлыг хийхэд хүндрэл учраад байна.

Логистик үйлчилгээний бизнесийг хөгжүүлэх зорилтын хүрээнд дотоод болон хил дамнасан и-худалдааны үйлчилгээг нэвтрүүлсэн. Энэ төрлийн үйлчилгээнээс 2016 оны байдлаар 900 сая төгрөгийн орлого олсон нь компанийн нийт орлогын 10 шахам хувийг эзэлж байна. Цаашид ОХУ болон БНХАУ-ын холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааны тогтвортой байдлыг хангах, цаашдын үйл ажиллагааг өргөжүүлэн ажиллавал өсөн нэмэгдэх ирээдүйтэй үйлчилгээ болох юм.

Компанийн хэмжээнд хэрэгжүүлэхээр зорьсон нийт 178 ажил төлөвлөж, 91%-ийн гүйцэтгэлтэй байна. Төлөвлөсөн ажлаас 16 нь огт хийгдээгүй нь Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газраас ирүүлсэн 2016 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн 1/10 тоот албан бичгийн дагуу хэмнэлтийн горимд шилжин ажиллах зайлшгүй шаардлага тулгарсан, хамтран ажилладаг зарим байгууллагын хариуцлагагүй байдал зэргээс шалтгаалжээ. Үүнээс 6 ажлын гол шалтгаан нь Дотоод хяналтын алба нь бүрэн бүрэлдэхүүнээр ажиллаж чадаагүй явдал юм.

Бид 2017 онд хийж хэрэгжүүлж байсан ажлуудыг амжилттай үргэлжлүүлэх, гарч байгаа хүндрэлийг даван туулах, шинээр гарц хайх, шинэ үйлчилгээ нэвтрүүлэх зэрэгт дүгнэлт хийсний үндсэн дээр дараах зорилго, зорилтуудыг дэвшүүлж ажиллахаар төлөвлөж байна.

**1. Хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлэх замаар шуудангийн уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, шуудангийн байгууллагын шинэ өнгө төрхийг тодорхойлж, орчин үеийн мэдээллийн технологид суурилсан шуудангийн үндсэн сүлжээг өргөтгөх зорилгын хүрээнд:**

- Компанийн зах зээлд эзлэх байр суурь нэр хүндийг өсгөх замаар шуудангийн уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зах зээлийг өргөжүүлэх;
- Шуудангийн салбар нэгжүүдийн байршил, хамрах хүрээг оновчтой болгох;
- Шуудан хүргэлтийн шинэ технологийг нэвтрүүлэх;
- Шуудангийн салбар нэгжүүдийн өнгө төрхийг тодорхойлон, бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх ребрэндингийн ажлыг хийх;
- Шуудангийн уламжлалт нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ тарифыг боловсронгуй болгох;
- Шуудангийн ажилтнуудын болон харилцагч байгууллагуудад олгох урамшууллын системийг бий болгох;
- Хөдөө орон нутгийн шуудангийн салбаруудын шуудан хүргэлтийн өртгийг бууруулах, алдагдлыг багасгах;
- Шуудангийн стандартын шаардлагыг хангасан, зах зээлийн боломжуудыг цогцоор шийдвэрлэсэн нэгдсэн агуулахыг барьж байгуулах;
- 

**2. Дотоодын болон олон улсын тээвэр зууч, транзит тээвэр, логистикийн үйлчилгээг эхлүүлэх зорилгын хүрээнд:**

- Олон улсын болон дотоодын логистик, тээвэр зуучийн үйлчилгээг нэвтрүүлэх дэд бүтцийн болон технологийн шийдлүүдийг тодорхойлох, шийдвэрлэх;
- Олон улсын транзит шуудангийн үйлчилгээг өргөжүүлэх, хөгжүүлэх;
- Дотоод логистик тээврийн үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх;

- Дотоод логистик тээврийн үйлчилгээний чиглэлийг нэмэгдүүлэх, бүх аймгийн төвүүдэд логистик үйлчилгээг эхлүүлэх;
- Гаалийн бүрдүүлэлт хийх мэргэжилтэн бэлдэх, бүрдүүлэлт хийж, олон улсын тээвэр зуучийн үйлчилгээг эхлүүлэх;
- 

**3. Шуудангийн үндсэн сүлжээг ашиглан санхүүгийн нэгдсэн үйлчилгээг эхлүүлэх ажлын хүрээнд зорилгын хүрээнд:**

- Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх хууль эрх зүйн орчныг тодорхой болгох ажлын хэсэг байгуулж, тодорхойлох;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран, шуудангийн үндсэн үйлчилгээгээр дамжуулж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх;

“МОНГОЛ ШУУДАН” ХК

